МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**АХЛАХ ШИНЖЭЭЧ Н.ХУЛАНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН**
**ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ/

*ХЯНАСАН:*

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ............................ /Ц.АРИУНСАНАА/

*ТАЙЛАГНАСАН:*

ТӨСВИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ ............................ /Н.ХУЛАН/

Тэмдэг ............................

(огноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ НЯМЖАВЫН ХУЛАНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 6.1. Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих** | | | | | | | |
| 6.1 | **Арга хэмжээ 6.1.2:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын багцад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлнэ. | **ШҮ1**: Хугацаа 2026 оны төсвийн урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл **ШҮ2**: Батлагдсан төсөв | ТЕЗ-ийн 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл | Төсвийн тухай хууль болон журамд заасан хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцийн 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналын урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, | **1.** Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээнүүдийн урьдчилсан үнэлгээг аймгууд болон чиг үүргийн газруудаас ирүүлсэн санал үндэслэн боловсруулсанаар нийт 734.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 385.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 62 төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/574 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд төсвийн | 2025.01.01 2025.12.31 | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн хүргүүлнэ. | хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр мөн илгээсэн.<br>**2.** Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад хэрэжүүлэхээр төлөвлөсөн 943.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг холбогдох тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/2272 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>**3.** Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хязгаарт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаас хүргүүлэх саналыг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулсанаар яамны урсгал зардалд 139.6 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 1 их наяд 44.6 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжийн зардалд 208.9 тэрбум төгрөг буюу нийт 1 их наяд 393.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг холбогдох тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/2272 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **4.** Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /ТЕЗ/-ын багцийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулсан бөгөөд урсгал зардалд 177.3 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 592.7 тэрбум төгрөг, гадаад зээл тусламжаар хэрэгжүүлж буй төслүүдэд шаардагдах 323.9 тэрбум төгрөг буюу нийт 770.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/2780 дугаартай албан бичгээр болон цахим системээр Сангийн яаманд, 01/2782 дугаартай албан бичгээр УИХ-д, 01/2781 дугаартай албан бичгээр ҮАГ-т тус тус хүргүүлсэн.<br>**5.** Сангийн яамнаас ирүүлсэн 2025 оны 02/7190 дугаартай албан бичгийн дагуу Засгийн газрын 2024 оны 93 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-д зааснаар ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдөр танхимаар, 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд яамны цахим хуудсаар тус хэлэлцүүлэн санал асуулга авч нийт 106 хуудас бүхий хэлэлцүүлгийн тайланг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02/3050 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаартай албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн. | | |
| 6.1 | **Арга хэмжээ 6.1.4:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцийн батлагдсан төсвийн санхүүжилтийн хуваарийн саналыг боловсруулан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулна. | **ШҮ1**: Батлагдсан санхүүжилтийн сар, улирлын хуваарь | Санхүүжилтийн сар, улирлын хуваарь-4 /тухай бүр/ | Санхүүжилтийн сар, улирлын хуваарь-4 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад 2025 оны төсвийн жилд зарцуулахаар анх батлагдсан 354.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан нэгтгүүлж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулсан. | 2025.01.01<br>2025.12.31 | 94 |
| 6.1 | **Арга хэмжээ 6.1.5:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрхийг Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, нийслэлд шилжүүлэх, багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг боловсруулан, батлуулж, холбогдох шийдвэрийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | **ШҮ1:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаал | Эрх шилжүүлсэн болон багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг батлуулсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаал | Багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг журамд заасан хугацаанд батлуулан хүргүүлэх | **1.** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад багц дүнгээр батлагдсан 235.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 63.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 3 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 40 төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг тухай бүр боловсруулан "Жагсаалт батлах тухай" Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 20, 21, 46 дугаар, "Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай" 58 дугаар, "Жагсаалт шинэчлэн батлах тухай" 65, 91, 162 дугаар тушаалууд;<br>**2.** Үүнээс 63.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 11 төсөл, арга | 2025.01.01<br>2025.12.31 | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоол болон “Жагсаалт батлах тухай” холбогдох тушаалуудыг үндэслэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад “Эрх шилжүүлэх тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 24, 25, 45, 92, 93 дугаар тушаалууд;<br>**3.** “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу 2024 онд зохицуулалт хийгдсэн 373.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 112.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж “Хөрөнгийн зохицуулалт хийх тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 13 дугаар тушаал,<br>**4.** 2024 онд зохицуулалт хийгдсэнтэй холбогдуулан 2025 онд шилжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад багц дүнгээр тусгагдсан 287.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 79.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 5 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 46 төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн боловсруулж “Жагсаалт батлах тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 14 дугаартай тушаал буюу нийт дээр дурдсан 14 тушаалыг тус тус батлуулж журамд заасны дагуу хугацаанд нь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сангийн яам болон холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн. | | |
| **Зорилт 6.4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах** | | | | | | | |
| **6.4** | **Арга хэмжээ 6.4.1:** Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төсөл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулна. | **ШҮ1:**Хэрэг жилт 90 хувиас дээш байх<br><br>**ШҮ2:Х**уулийн хугацаанд байршуулсан мэдээллийн тоо | 2024 онд шилэн дансанд байршуулсан мэдээний тоо-26;<br><br>Хэрэгжилтийн хувь 100% | Шилэн дансанд байршуулах мэдээллийн тоо-26<br><br>Хэрэгжилт-100% | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг 1 удаа, дараа жилийн төсвийн төслийн 1 удаа, тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 12 удаа, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 12 удаа тухай бүр шилэн дансанд тогтмол мэдээлж, хуулийн хугацаанд байршуулсан. | 2025.01.01<br>2025.12.31 | 93 |

Нэмэлт арга хэмжээний биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг гарган дүгнүүлэх, хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох тушаал шийдвэрийн биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гарган танилцуулах | ШҮ1: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт<br><br>ШҮ2: Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | Хэрэгжилт-96% | Хэрэгжилтийн хувь-90-100% | **1.** ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт нийт 3 удаа;<br>**2.** Хариуцсан чиг үүргийн дагуу хуулийн төсөл /1/ болон ЗГ-ын тогтоолын төслүүдэд өгсөн санал /2/ нийт 3;<br>**3.** Хот, байгуулалт, орон сууцжуулалтын сайдын тушаалын төсөл боловсруулалт, баталгаажуулалт нийт 14;<br>**4.** Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан нийт 2;<br>**5.** СХОГ-ын чиг үүрэг болон холбогдох албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтыг нэгтгэн боловсруулж, хянуулсан;<br>**6.** ТЕЗ-ийн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаарын санал, төсвийн төсөл буюу төлөвлөлттэй холбогдох шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр хугацаанд нь гарган | 2025.01.01<br>2025.12.31 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулж, баталгаажуулан ажилласан. | | |
| 2 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | ШҮ1: Ирсэн явсан албан бичгийн тоо<br>ШҮ2: Албан бичгийн шийдвэрлэлт | Нийт 202 албан бичгийг хугацаанд нь судлан танилцуулж, шийдвэрлэсэн.<br><br>28 материал архивт хүлээлгэн өгсөн. | Хэрэгжилтийн хувь-100% | Холбогдох хууль, журам, зааврын дагуу тайлант хугацаанд ирсэн нийт 185 албан бичгийг хугацаанд нь судлан танилцуулж, шийдвэрлэсэн. | 2025.01.01<br>2025.12.31 | 92 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдаж буй холбогдох сургалтуудад хамрагдах | Сангийн яам болон холбогдох байгууллагаас зохион байгуулах төсвийн төлөвлөлттэй холбогдох сургалт семинарт хамрагдана. | 2 удаа | 2 удаа | 1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн Б/68 дугаар тушаалаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан “Төслийн түншлэгч талуудын барилгын дулаан шинэчлэл, барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулааны хэрэглээнд суурилсан үнэ тариф болон санхүүгийн тогтвортой механизмыг нэвтрүүлэх боломжийг нэвтрүүлэх нь” сургалтад 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 07-ний өдрүүдэд оролцон туршлага судалсан. | 2025.01.01<br>2025.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Сангийн яамнаас дээрх хугацаанд буюу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын чадавх бэхжүүлэх” сургалтад цахимаар хамрагдсан.<br>3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/204 дүгээр тушаалаар Япон улсын барилга, орон сууцны эрчим хүчний хэмнэлт, пассив болон ногоон барилга байгууламжид хэрэгжүүлж байгаа бодлого, шинэ технологитой танилцах зорилгоор тус улсын Токио, Саппоро хотуудад 2025 оны 12 дугаар сарын 06-ний өдрөөс 14-ний өдрүүдэд томилолтоор ажиллан туршлага судалсан. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ** **Н.ХУЛАН**

........................................ 2025 оны 12 sarын 15 өдөр

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

**ТӨСВИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Н.ХУЛАНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 6.1. Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих** | | | | | |
| 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын багцад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлнэ. | 55 | 10 | 65 | 64.8 |
| 2 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцийн батлагдсан төсвийн санхүүжилтийн хуваарийн саналыг боловсруулан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулна. | 55 | 10 | 65 | 64.8 |
| 3 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрхийг Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, нийслэлд шилжүүлэх, багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг боловсруулан, батлуулж, холбогдох шийдвэрийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | 55 | 10 | 65 | 64.8 |
| **Зорилт 6.4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах** | | | | | |
| 1 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төсөл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулна. | 55 | 10 | 65 | 64.8 |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг гарган дүгнүүлэх, хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох тушаал шийдвэрийн биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гарган танилцуулах | 55 | 10 | 65 | 64.8 |
| 2 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг . шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | 55 | 9 | 64 | 65 |
| | **Дундаж оноо:** | | | **64.8** | **64.8** |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдаж буй холбогдох сургалтуудад хамрагдах | 100 | 15 | 15 |
| **Дундаж оноо** | | | **15** | **15** |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6 | 6 |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6 | 6 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | 6 |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | 7 |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8 | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | **6.5** | **6.5** |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | **8** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 64.8 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15.0 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6.5 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8.0 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **94.3** |

***Үнэлгээ өгсөн:***

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Нэгжийн дарга

............................ (гарын үсэг)

Ц.АРИУНСАНАА

............................ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

СХОГ-ын Ахлах шинжээч

***Төрийн жинхэнэ албан хаагч:***

............................ *(гарын үсэг)*

Н.ХУЛАН

............................ *(огноо)*

*Үнэлгээг хянасан:*
*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................................ Б.БАТ-ЭРДЭНЭ

(гарын үсэг)

........................ (огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ТЗУГ-ын Хүний нөөц, шагнал хариуцсан ахлах шинжээч ............................................ Т.ЯНЖМАА

(гарын үсэг)

........................ (огноо)

*Үнэлгээг баталгаажуулсан:* **Төсвийн шууд захирагч**

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................................ М.БАЯРАА

(гарын үсэг)

........................ (огноо)